

		Баримт бичгийн дугаар: 3-Ж-010	
Баталсан: ..... Голлоодог удирдах зөвлөл		Баталсан огноо: 2023/06/20	Хуудасны тоо: 7
Баримт бичгийг хариуцагч: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Танилцах албан тушаалтнууд: ББСБ-н хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага		

## ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам Эх хувь

### ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн бүртгэлийг энэхүү баримт бичигт өөрчлөлт оруулах хүсэлтэд үндэслэн хөтлөх ба энэ тохиолдолд өөрчлөлтийг эрх бүхий албан тушаалтан баталсан байна.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

## АГУУЛГА

АГУУЛГА .....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН .....	3
ГУРАВ. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА .....	3
ДӨРӨВ. ХОРООНЫ ХУРАЛ .....	3
ТАВ. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЭРХ .....	4
ЗУРГАА. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА .....	4
ДОЛОО. НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	5
НАЙМ. АЖЛЫН ТАЙЛАН .....	6
ЕС. БУСАД .....	7

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (“Хороо” гэх) нь ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, салбарын захирал, Эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах бодлого, журмыг боловсруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 1.2. Хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

## ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1. Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ нь Хорооны гишүүд болон даргыг томилно. Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.
- 2.2. Хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.
- 2.3. Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд томилогдох хүртэл ажил үүргээ гүйцэтгэнэ.

## ГУРАВ. ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

- 3.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хорооны нарийн бичгийн дарга байна.
- 3.2. Хорооны нарийн бичгийн дарга нь хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж, хорооны хурлыг зохион байгуулах ажлыг хариуцна.

## ДӨРӨВ. ХОРООНЫ ХУРАЛ

- 4.1. Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг хэдийд ч хуралдуулж болно.
- 4.2. Хурал нь гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд биеэр, эсвэл цахим хэрэгсэл ашиглан оролцож болно.
- 4.3. Хорооны гишүүдийн хүсэлтээр хорооны хуралд компанийн удирдлагууд, гадны зөвлөхүүд оролцож болно. Бусад тохиолдолд Хорооны хуралд гишүүдээс бусад этгээд оролцох эрхгүй.
- 4.4. Хорооны дарга нь хурлын тов, хэлэлцэх асуудлыг тодорхойлох бөгөөд хурлын зарыг 14 хоногийн өмнө хүргүүлнэ. Гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудалд оруулах саналаа хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.
- 4.5. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг гишүүдэд урьдчилан хүргүүлсэн байна.
- 4.6. Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга хагалах эрхтэй.



## ТАВ. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЭРХ

- 5.1. Нэр дэвшүүлэх хорооны гишүүд нь дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 5.1.1. Компанийн хэмжээнд баримтлах нэр дэвшүүлэх бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад санал зөвлөмж өгөх;
  - 5.1.2. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг үнэлэх, дахин нэр дэвшүүлэх, улируулан томилохтой холбогдуулан шаардлагатай тохиолдолд Компанийн зардлаар гадны хуулийн болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авах;
  - 5.1.3. Хуралд саналын эрхтэй оролцох;
  - 5.1.4. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах
  - 5.1.5. Гүйцэтгэх удирдлага, Компанийн ажилтнуудаас Нэр дэвшүүлэх хорооны нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардах;

## ЗУРГАА. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Хороо нь дор дурдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 6.1.1. ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулахад тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
  - 6.1.2. ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд шаардлага хангаж байгаа эсэхэд жил бүр үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - 6.1.3. Хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлнэ. Ингэхдээ:
    - 6.1.3.1. ТУЗ-д нэр дэвшүүлэх эрх бүхий Компанийн хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшүүлж буй этгээдийн тухай мэдээллийг хүлээн авах;
    - 6.1.3.2. тухайн этгээд нь хууль болон хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах, шалгуур хангахгүй байгаа бол энэ тухай нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлэх;
    - 6.1.3.3. хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол хараат бус гэдгийг нотлох мэдээлэл, уг мэдээлэл үнэн зөв болох тухай нэр дэвшигчийн баталгаа зэргийг гаргуулах;
    - 6.1.3.4. дээрх мэдээлэлд үндэслэн нэр дэвшигчийг саналын хуудсанд оруулах тухай саналаа ТУЗ-ийн хуралд танилцуулах.
  - 6.1.4. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - 6.1.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;
  - 6.1.6. Компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд хяналт тавих, дүгнэлт гаргах;

- 6.1.7. ТУЗ-ийн гишүүн нас барсан, удаан хугацаагаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ-ийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар нөхөн сонгох гишүүний нэрийг дэвшүүлэх асуудлыг хариуцан гүйцэтгэх.
- 6.1.8. Хороо нь Компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, салбарын захирал, эрх бүхий албан тушаалтнуудад ажиллаж буй этгээдүүдийг сонгон шалгаруулах бодлогыг тодорхойлохдоо хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах асуудлыг тусгах;
- 6.1.9. Хууль тогтоомжид заасан эсхүл ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудал.
- 6.2. Хороо нь залгамж халааны бодлогыг боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.
- 6.3. Хороо нь компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох ба Хороо нь тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.
- 6.4. Хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Компанийн зүгээс хүлээлгэн өгсөн, танилцуулсан болон нэр дэвшигчийн хувийн нууцад хамаарах бүхий л төрлийн мэдээ, мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулах, аливаа хэлбэрээр дамжуулахгүй байх үүрэгтэй.
- 6.5. Энэ Дүрмийн 6.4-т заасан этгээдүүд Компанийн нууц мэдээллийг задруулсны улмаас хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулах ба ТУЗ-ийн шийдвэрээр чөлөөлөх хүртэл арга хэмжээг авна.

### **ДОЛОО. НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 7.1. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал, салбарын захирал, эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дараах тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байна. Үүнд:
  - 7.1.1. Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн болон Хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн бусад мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;
  - 7.1.2. Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай байх;
  - 7.1.3. Санхүүгийн салбарт 2-аас доошгүй жил ажилласан байх.
  - 7.1.4. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх;
  - 7.1.5. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх.
  - 7.1.6. сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авахуулаагүй байх;
  - 7.1.7. санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх;



- 7.1.8. сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;
- 7.1.9. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;
- 7.1.10. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.
- 7.1.11. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;
- 7.1.12. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль журамд харшлаагүй байх.
- 7.1.13. Хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад шалгуурыг хангасан байх.
- 7.1.14. ТУЗ-ийн ердийн гишүүн нь 7.1-д зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
  - 7.1.15. зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
  - 7.1.16. ял шийтгэлгүй;
  - 7.1.17. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвших этгээд 7.1-д зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
    - 7.1.18. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
    - 7.1.19. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
    - 7.1.20. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
    - 7.1.21. компанитай бизнесийн аливаа холбоогүй.
    - 7.1.22. зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
    - 7.1.23. ял шийтгэлгүй;

### НАЙМ. АЖЛЫН ТАЙЛАН

- 8.1. Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн чухал санал, дүгнэлтийг багтаасан байна.
- 8.2. Хороо нь албан үүргийнхээ хүрээнд хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнана.

- 8.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд залгамж халааны бодлогын баримт бичиг, Хорооны үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирц зэргийг тусгаж нийтэд мэдээлнэ.

### ЕС. БУСАД

- 9.1. Хороо нь энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д саналаа гаргаж болно.
- 9.2. Энэхүү Дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн дараагийн өөрчлөлт орох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

\*\*\*\*\*

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ